



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 10 өдөр

Дугаар A/214

Хэрлэн сум

Г Нутгийн иргэд аялал жуулчлалын
үйлчилгээ үзүүлэх журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Аялал жуулчлалын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.1 дэх заалт, Засгийн газрын 2022 оны 419 дүгээр тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны Есдүгээр хуралдааны 06 дугаар тогтооюор батлагдсан “Хэнтий аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх хөтөлбөр-2030”-ийн 3.6-д заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нутгийн иргэдэд түшиглэсэн эко аялал жуулчлалыг дэмжиж иргэдийн амьжиргааг сайжруулах, нийгэм, эдийн засгийн өгөөжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд “Нутгийн иргэд аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэх журам”-ыг хавсралтаар баталсугай.

2.Журмын дагуу иргэдийн аялал жуулчлалын үйл ажиллагаа үзүүлэх ажлыг өөрийн орон нутгийн онцлогтоо тохируулан зохион байгуулж, холбогдох байгууллагыг мэдээллээр хангаж хамтран ажиллахыг сумын Засаг дарга наарт үүрэг болгосугай.

3.Журмын хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр дэмжиж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Б.Дархантөр), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Э.Мөнх-Эрдэнэ)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2023 оны
дугаар сарын 10-ны өдрийн
дугаар захирамжийн хавсралт

НУТГИЙН ИРГЭД АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл:

1.1. Энэхүү журмын зорилго нь Чингис хот болон бусад сумдын нутаг дэвсгэр, төв суурин газарт орон нутгийн иргэд, гадаад дотоодын аялагч, жуулчдад аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энэхүү журам нь Аялал жуулчлалын тухай, Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, Татварын тухай, бусад холбогдох Монгол улсын хуультай нийцүүлэн гаргасан дүрэм, журам, Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр, аймгийн Аялал жуулчлалыг хөгжүүлэх хөтөлбөртэй нийцсэн байна.

1.3. Аялал жуулчлалын үйлчилгээ гэж зочны гэр, отоглох, хоноглох цэг ажиллуулах, морин хөтөч хийх, уламжлалт хоол хүнс, цагаан идээгээр үйлчлэх зэргийг ойлгоно.

Хоёр. Аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэх этгээд хүсэлт гаргах:

2.1 Тухайн сум, орон нутгийн иргэн аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулах хүсэлтээ сумын Засаг даргад бичгээр гаргах бөгөөд түүнд доор дурдсан баримт бичгийг хавсаргана.

2.1.1 Тухайн этгээдийн явуулах үйл ажиллагааны чиглэл, хүчин чадлыг тусгасан нотлох баримт,

2.1.2 Иргэний үнэмлэхний хуулбар,

2.1.3 Оршин суух газрын хаягийн тодорхойлолт,

2.1.4 Үйл ажиллагаа явуулах байршил тогтоосон солбицол

2.2 Сумын Засаг дарга хүсэлтийг хүлээн авч доор дурдсан ажиллагаа явуулна.

2.2.1 Хүсэлтийг хүлээн авч, судлан 30 хоногийн дотор шийдвэрлэнэ

2.2.2 Хүсэлтийг хүлээн авч, ирүүлсэн дарааллын дагуу бүртгэн, түүнд хавсаргасан баримт, бичгийг дугаарлан бүртгэнэ,

2.2.3 Хүсэлт түүнд хавсаргасан баримт, бичиг нь үнэн зөв эсэхийг нягтлан шалгаж, шаардлага хангагүй хүсэлтийг буцаахдаа үндэслэлийг тусган хүсэлт гаргасан этгээдэд албан бичгээр мэдэгдэнэ.

2.2.1.3 Шаардлага хангасан хүсэлт ирүүлсэн этгээдтэй тухайн сумын Засаг дарга гэрээг Иргэний болон бусад холбогдох хуулийн хүрээнд байгуулна.

Гурав. Аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэхэд тавигдах нийтлэг шаардлага

3.1 Үйлчилгээ үзүүлэх хүсэлт гаргах этгээд насанд хүрсэн байна. Мөн үйлчилгээ үзүүлэгч ажилчид нь Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/145 дугаар тушаалаар батлагдсан "Худалдаа, үйлчилгээний байгууллагын ажилтныг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулах журам"-ын дагуу үзлэг шинжилгээнд хамрагдаж эрүүл эсэхээ баталгаажуулсан байна.

3.2 Аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэгч этгээд нь холбогдох сумын Засаг даргын Тамгын газартай гэрээ байгуулсан байна.

3.3 Байгаль орчин, аялал жуулчлалын газраас зочны гэр, отоглох цэг ажиллуулахаар гэрээ байгуулсан этгээдэд "Гэрчилгээ", "Үнэмлэх"-ийг тус тус гурван жилийн хугацаагаар олгох бөгөөд гэрээний хэрэгжилтийг үндэслэн сунгалтыг жил бүр хийнэ.

3.4 Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдсон асуудлаар эрх бүхий байгууллагаас зохион байгуулсан сургалтад хамрагдаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө авсан байна.

3.5 Үйлчилгээ үзүүлэгч этгээд эрүүл ахуйн шаардлага хангасан итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээгээр баталгаажсан ундны усаар үйлчилнэ.

3.6 Аянхны тусламж үзүүлэх эм хэрэгслийн нөөцтэй байна.

3.7 Аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэгч этгээд гэрээний хугацаанд, тогтоосон хураамжийг холбогдох дансанд төвлөрүүлж, гэрээний биелэлтэд хавсаргасан байна.

Дөрөв. Зочны гэр ажиллуулахад тавигдах шаардлага

4.1 Нийтлэг шаардлага

4.1.1 Зочны гэр ажиллуулахаар гэрээ байгуулсан этгээд 5 хүртэл гэр барих ба үүний 1 гэр нь гал тогооны үйлчилгээний зориулалттай байна.

4.1.2 Гэр хоорондын зайд 5 метрээс доошгүй байх ба байгалийн үзэгдэл, аадар бороо, мөндөр, салхи шуурга, галын аюулгүй байдал, амрагчдын ая тух, аюулгүй байдлыг хангасан байна.

4.1.3 Зочны гэр ажиллуулж буй өрх тус бүр жуулчны бааз, өөр хоорондоо 1 км-ээс багагүй зайдтай байрлана. Зөвшөөрөгдсөн бүсэд нүүдэлчин соёл, уламжлалт зан заншлыг харуулах зорилгоор малчин өрхийн дэргэд байж болно.

4.1.4 Зочны гэр ажиллуулах өрх өөрсдийн амьдрах гэрийг зочин хүлээн авах гэрүүдээс 30 метрээс доошгүй зайд салхин дор байрлуулна.

4.1.5 Зочны гэр, үйлчилгээ үзүүлэх орчин, авто машины зогсоол зэрэгт тэг гортиг татаж, тэмдэг тэмдэглэгээ байрлуулна.

4.1.6 Зочны гэр ажиллуулж буй өрх байгальд ээлтэй био жорлонтой байх ба жорлон нь хүлээн авах нийт зочны тооны 30 хүн тутамд 1 эр, 1 эм байхаар зохион байгуулсан байна.

4.1.7 Энгийн хуурай хог хаягдлыг ангилан ялгаж, шаардлага хангасан түр цэгт хадгалан, дахивар түүхий эд авах цэгт болон хогийн нэгдсэн цэгт тус тус хургэнэ.

4.2 Зочны гэрт тавигдах шаардлага:

4.2.1 Зочны гэр нь өнгө үзэмж сайтай, хаалга дотор, гадна түгжээтэй байна.

4.2.2 Зочин хүлээн авах гэрүүд нь нэгэн жигд бүрээстэй, амьдарч буй гэрээс ялгарах тэмдэг, өнгө, дугаартай байна.

4.2.3 Орны гудас, цагаан хэрэглэл нь цулгүй цайвар өнгөтэй, хөвөн зөөлөн даавуугаар хийгдсэн 2-оос доошгүй ээлжтэй, тусгай битүү шүүгээнд хадгална.

4.2.4 Зочны гэр нь ширээ, гар угаалтуур, гарын алчуур, угааж цэвэрлэхэд хялбар шал, гэрэл, цахилгааны эх үүсвэр, усны сав, зуух, орны тоогоор мөр өлгүүр, сандал, цайны болон хоолны аяга, таваг, халбага сэрээтэй байна.

4.2.5 Зочны гэр болон ариун цэвэр, угаалгын хэсэгт ариутгал, халдвартгүйжүүлэлтийг хийх боломжтой байна.

4.2.6 Зочны гэр тус бүрт галын аюулаас урьдчилан сэргийлэх анхааруулах хуудас, гал унтраах галын хор, түүнийг ажиллуулах зааварчилгааны хамт байршуулсан байна.

Тав. Отоглох, хоноглох цэг ажиллуулахад тавигдах шаардлага

5.1.1 Аялагчдын майхан платка барих талбай, машин, тээврийн хэрэгслийн зогсоол, гал тулэх цэг, ус авах цэг зэргийг байгалийн чулуу, шохой зэрэг материалаар хা�ших, тэг гортиг татах, тэмдэгжүүлэх зэрэгээр байгаль орчинд сөрөг нөлөөгүй байдлаар тохижуулна.

5.1.2 Отоглох цэг нь аялагч жуулчид, амрагчдыг байрлуулах үндсэн үйл ажиллагаанаас гадна стандарт шаардлага, аюулгүй байдлыг хангасан байгальд ээлтэй аяллын морин хөтөч, соёлын биет болон биет бус үзвэр, хүнсний бүтээгдэхүүн, цагаан идээ, мод түлээ, бэлэг дурсгалын үйлчилгээ явуулж болно.

5.1.3 Отоглох цэг нь энгийн нүхэн жорлонг ашиглахгүй ба байгальд ээлтэй технологи бүхий эко жорлонтой байна.

5.2 Отоглох цэгийн үйлчилгээ эрхлэгчдэд тавигдах шаардлага

5.2.1 Отоглох, хоноглох цэгт байрлагчдын товч бүртгэлийг хөтөлсний дагуу улирлаар гарган дараа улирлын 10-ны дотор аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар болон сумын Засаг даргын Тамгын газарт хүргүүлнэ.

5.2.2 Орон нутгийн түүх соёлын дурсгалт зүйл, онцлог, байгалийн үзэсгэлэнт болон түүхийн дурсгалт газруудын танилцуулга, маршрут болон холбогдох хууль, журам, дүрмийн талаар үнэн зөв бодит мэдээллийг жуулчид, аялагч, амрагчдад өгнө.

5.2.3 Отоглох цэгийн үйлчилгээ эрхлэгч нь хариуцаж байгаа цэгийн орчны цэвэрлэгээ, аялагч, амрагчдын тав тухтай байдлыг ханган, Байгаль орчин аялал жуулчлалын газар болон холбогдох газруудаас өгсөн зөвлөмж, үүрэг даалгаврыг хэрэгжүүлж ажиллана.

Зургаа. Үйлчлүүлэгчид тавигдах нийтлэг шаардлага

6.1 Зочны гэр болон отоглох цэгээр үйлчлүүлж байгаа аялагч, амрагч, жуулчид тээврийн хэрэгсэл, авто машинаа тэмдэг, тэмдэглэгээ бүхий зогсоолд байрлуулна.

6.2 Отоглох цэг ашигласны болон зочны гэрийн төлбөрийг тогтоосон тарифаар төлж, баримтыг авна.

6.3 Аялагчид майхан, платкаа отоглох цэгийн тусгайлан заасан талбайд барих бөгөөд 4 майхан тутам зориулалтын нэг галын цэгтэй байна.

6.4 Тусгайлан бэлтгэж өгсөн хогийн уутанд энгийн болон аюултай хог хаягдлыг ангилан хийж, тогтоосон цэгт хаяна.

Долоо. Хориглох зүйл

7.1 Газар хөндөх, ухах, мод отглох хугалах, зөвшөөрөөгүй цэгт ил гол түлэх, гол ус, хөрс, агаар орчныг бохирдуулах, ил задгай хог хаях, бие засахыг хориглоно.

7.2 Зочны гэр, ил талбайн ширээ сандал, гол түлэх зориулалтын цэг, бие засах газар, машины зогсоол, самбар, тэмдэг, тэмдэглэгээ зэрэг талбай тохижуулсан эд зүйлийг эвдэх гэмтээхийг хориглоно.

7.3 Монгол улсын хууль тогтоомжид заагаагүй, орон нутгийн шийдвэр гаргах эрх бүхий байгууллагын шийдвэрлгүйгээр ямар нэгэн төлбөр хураамж авах, төлөхийг хориглоно.

Найм. Хяналт

8.1 Зочны гэрийн үйл ажиллагаа болон отоглох цэг дээр буусан аялагчдын майхны даац хэтэрсэн, отоглох цэг хариуцагч тасалбараа зориулалтын дагуу тасалсан эсэхийг Тусгай хамгаалалттай газар нутгийн Хамгаалалтын захиргааны байгаль хамгаалагч, орон нутгийн засаг захиргааны нутаг дэвсгэрт эрх бүхий байгаль хамгаалагчид, холбогдох хяналтын Улсын байцаагчид хяналт тавина.

Ес. Журам хэрэгжих, Харицулага

9.1 Энэхүү журмыг зөрчсөн тохиолдолд Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу хариуцлага хүлээлгэнэ.